

## ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын  
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2023/03/НА-СТА-ОНА

|   |   |
|---|---|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179, Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a><br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Саруул баян уул- Аудит”<br>ХХК Захирал: Б.Шатар<br>Утас: 99093852 Цахим хаяг: <a href="mailto:Shatar5626@gmail.com">Shatar5626@gmail.com</a><br>Аудитор: Д.Оюунбат<br>Утас: 99973399 Цахим хаяг: <a href="mailto:Oyunbatdorjkhand@gmail.com">Oyunbatdorjkhand@gmail.com</a> |
| Говьсүмбэр аймаг<br>2023 он                                     |   |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....0

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....3-9

|   |       |
|---|-------|
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....                             | 10    |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....                          | 10    |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....                          | 10    |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                      | 10    |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгын өөрчлөлт..... | 11    |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                 | 12-13 |
| 4. Аудитын тайлан.....  | 13    |
| 4.1 Ерөнхий зүйл .....  | 13    |
| 4.2 Материаллаг байдал .....  | 13    |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....                        | 13    |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын .....  | 14    |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....        | 14    |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                       | 15    |
| 5. Аудитын илрүүлэлт .....  | 15    |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....                 | 16    |

---

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ХХК Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

НББОУС Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

НБББББ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| №  | Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|----|----------------------------------|------------------|------------------|
| 1  | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН          | 84,949,805.94    | 153,439,732.91   |
| 2  | МӨНГӨН ХӨРӨНГӨ                   | 1,977,875.08     | 27,528,116.49    |
| 3  | Кассанд байгаа бэлэн мөнгө       | 2,997.94         | 533,078.69       |
| 4  | Төгрөг                           | 2,997.94         | 533,078.69       |
| 5  | Банкинд байгаа бэлэн мөнгө       | 1,974,877.14     | 26,995,037.8     |
| 6  | Төгрөг                           | 1,974,877.14     | 26,995,037.8     |
| 7  | Арилжааны банк дахь харилцах     | 1,974,877.14     | 26,995,037.8     |
| 8  | АВЛАГА                           | 34,520,446.79    | 47,547,046.13    |
| 9  | Дансны авлага /ТӨҮГ/             | 31,566,761.99    | 44,157,110.83    |
| 10 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/     | 2,953,684.8      | 3,389,935.3      |
| 11 | БАРАА МАТЕРИАЛ                   | 48,451,484.07    | 78,364,570.29    |
| 12 | Хангамжийн материал              | 48,451,484.07    | 78,364,570.29    |
| 13 | Аж ахуйн материал                | 48,451,484.07    | 78,364,570.29    |
| 14 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН      | 1,304,956,047.59 | 1,356,740,372.26 |
| 15 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                   | 1,304,956,047.59 | 1,356,740,372.26 |
| 16 | Биет хөрөнгө                     | 1,254,642,047.59 | 1,302,166,372.26 |
| 17 | Барилга, байгууламж, орон сууц   | 1,140,732,852    | 1,140,732,852    |
| 18 | Хуримтлагдсан элэгдэл            | -172,797,231.04  | -196,586,681.68  |
| 19 | Авто-тээврийн хэрэгсэл           | 222,640,500      | 135,700,000      |
| 20 | Хуримтлагдсан элэгдэл            | -207,790,500     | -17,820,000      |
| 21 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 338,926,599      | 295,028,987.36   |
| 22 | Хуримтлагдсан элэгдэл            | -69,704,752.22   | -57,949,468.89   |
| 23 | Тавилга, аж ахуйн эд хогшил      | 9,383,416        | 7,902,816        |
| 24 | Хуримтлагдсан элэгдэл            | -6,748,836.15    | -4,842,132.53    |
| 25 | Биет бус хөрөнгө                 | 50,314,000       | 54,574,000       |
| 26 | Програм хангамж                  | 2,340,000        | 4,600,000        |
| 27 | Хуримтлагдсан элэгдэл            | -2,270,000       | -270,000         |
| 28 | Бусад биет бус хөрөнгө           | 50,244,000       | 50,244,000       |
| 29 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II      | 1,389,905,853.53 | 1,510,180,105.17 |
| 30 | НИЙТ ӨР ТӨЛБӨР                   | 306,312,962.52   | 383,836,154.25   |
| 31 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР        | 6,281,387.47     | 13,189,620.4     |
| 32 | Өглөг                            | 6,281,387.47     | 13,189,620.4     |
| 33 | Бусад өглөг                      | 6,281,387.47     | 13,189,620.4     |
| 34 | Байгууллагад төлөх өглөг         | 2,273,750        | 879,139.75       |
| 35 | Хувь хүмүүст төлөх өглөг         | 178,605          | 378,970          |
| 36 | Татварын өглөг /ТӨҮГ/            | 3,829,032.47     | 11,931,510.65    |
| 37 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР           | 300,031,575.05   | 370,646,533.85   |
| 38 | Урт хугацаат зээл                | 300,031,575.05   | 370,646,533.85   |
| 39 | Төгрөг                           | 300,031,575.05   | 370,646,533.85   |
| 40 | Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/     | 300,031,575.05   | 370,646,533.85   |
| 41 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН         | 1,083,592,891.01 | 1,126,343,950.92 |
| 42 | Засгийн газрын хувь оролцоо      | 1,083,592,891.01 | 1,126,343,950.92 |

|    |                                       |                  |                  |
|----|---------------------------------------|------------------|------------------|
| 43 | Засгийн газрын оруулсан капитал       | 1,572,400,240.2  | 1,572,400,240.2  |
| 44 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,572,400,240.2  | 1,572,400,240.2  |
| 45 | Хуримтлагдсан үр дүн                  | -575,111,678.83  | -532,360,618.92  |
| 46 | Өмнөх үеийн үр дүн                    | -602,182,348.24  | -592,979,203.54  |
| 47 | Тайлант үеийн үр дүн                  | 27,070,669.41    | 60,618,584.62    |
| 48 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү      | 86,304,329.64    | 86,304,329.64    |
| 49 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН   | 1,389,905,853.53 | 1,510,180,105.17 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант огноо: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| №  | Үзүүлэлт   | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН     |
|----|--|----------------|----------------|
| 1  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          | 151,273,141.91 | 244,770,921.73 |
| 2  | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 151,273,141.91 | 244,770,921.73 |
| 3  | Нийтлэг татварын бус орлого                              | 151,273,141.91 | 244,770,921.73 |
| 4  | Бусад орлого   | 17,242,449.72  | 72,877,518.45  |
| 5  | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/                       | 363,899,662.7  | 510,948,603.28 |
| 6  | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/                                | 229,868,970.51 | 339,055,200    |
| 7  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 124,202,472.5  | 184,152,337.11 |
| 8  | УРСГАЛ ЗАРДАЛ  | 124,202,472.5  | 184,152,337.11 |
| 9  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 124,202,472.5  | 184,152,337.11 |
| 10 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 124,202,472.5  | 184,152,337.11 |
| 11 | Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/                   | 10,706,309.53  | 16,057,762.97  |
| 12 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/                      | 110,121,833.73 | 146,132,856.84 |
| 13 | Бусад зардал /ТӨҮГ/                                      | 366,477.08     | 15,226,319.01  |
| 14 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/                           | 3,007,852.16   | 6,735,398.29   |
| 15 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    | 27,070,669.41  | 60,618,584.62  |
| 16 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          | 27,070,669.41  | 60,618,584.62  |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| №  | Үзүүлэлт                                   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1  | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -602,254,524.6    | 1,056,450,045.24                        |
| 2  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт |                                 |                       | 72,176.36         | 72,176.36                               |
| 3  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -602,182,348.24   | 1,056,522,221.6                         |
| 4  | Тайлант үеийн үр дүн                       |                                 |                       | 27,070,669.41     | 27,070,669.41                           |
| 5  | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -575,111,678.83   | 1,083,592,891.01                        |
| 6  | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл        | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -575,111,678.83   | 1,083,592,891.01                        |
| 7  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт |                                 |                       | -17,867,524.71    | -17,867,524.71                          |
| 8  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -592,979,203.54   | 1,065,725,366.3                         |
| 9  | Тайлант үеийн үр дүн                       |                                 |                       | 60,618,584.62     | 60,618,584.62                           |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл      | 1,572,400,240.2                 | 86,304,329.64         | -532,360,618.92   | 1,126,343,950.92                        |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| №  | Үзүүлэлт   | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН     |
|----|--|----------------|----------------|
| 1  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                             | 391,251,504.38 | 541,416,196.44 |
| 2  | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 391,251,504.38 | 541,416,196.44 |
| 3  | Нийтлэг татварын бус орлого  | 391,251,504.38 | 541,416,196.44 |
| 4  | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/                | 391,251,504.38 | 541,416,196.44 |
| 5  | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                  | 385,655,304.71 | 515,865,955.03 |
| 6  | УРСГАЛ ЗАРДАЛ  | 385,655,304.71 | 515,865,955.03 |
| 7  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                    | 385,655,304.71 | 515,865,955.03 |
| 8  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                  | 113,671,794.24 | 176,894,464.83 |
| 9  | Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/   | 113,671,794.24 | 176,894,464.83 |
| 10 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                     | 53,045,915.64  | 40,865,823.08  |
| 11 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/                      | 53,045,915.64  | 40,865,823.08  |
| 12 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                          | 27,620,081.21  | 24,299,459.48  |
| 13 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/                                   | 27,620,081.21  | 24,299,459.48  |
| 14 | Хангамж, бараа материалын зардал                                   | 141,249,609    | 180,405,457.48 |
| 15 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 91,838,810     | 77,574,561.25  |
| 16 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/                       | 49,410,799     | 102,830,896.23 |
| 17 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж           | 50,067,904.62  | 93,400,750.16  |
| 18 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/                                | 37,220,087     | 50,018,719.09  |
| 19 | Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/                               | 1,089,525      | 13,605,715.55  |
| 20 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/  | 11,758,292.62  | 29,776,315.52  |
| 21 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)                | 5,596,199.67   | 25,550,241.41  |
| 22 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                          | 4,709,500      |                |
| 23 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 4,709,500      |                |
| 24 | Дотоод эх үүсвэрээр  | 4,709,500      |                |
| 25 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                     | 4,709,500      |                |
| 26 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                            | -4,709,500     |                |
| 27 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)                  | 886,699.67     | 25,550,241.41  |
| 28 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                   | 1,091,175.41   | 1,977,875.08   |
| 29 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                  | 1,977,875.08   | 27,528,116.49  |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа**

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь “Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа” бөгөөд тайлант жилийн үйл ажиллагааны зорилго нь “Хэрэглэгчдийг дулаан, хэрэглээний цэвэр усаар тогтмол найдвартай хангах болон бохир усыг татан зайлуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 тоот тушаалаар 24 орон тоо баталж, 18 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж, 6 орон тоо дутуу ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа НБББББ-г орлогыг-НББОУС-18, түрээсийг - НББОУС-17 -барилгын гэрээг НББОУС-11-г дагаж

мөрдөнө гэж заасан стандартууд хүчингүй болж, СТОУС-15, СТОУС-16 стандартуудыг мөрддөг болсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 120.2 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт     |            |
|--|----------------|-----------------|--------------|------------|
|  |                |                 | 3=2-1        | хувь       |
| Б  | 1              | 2               | 3=2-1        | хувь       |
| Мөнгөн хөрөнгө                               | 2.0            | 27.5            | 25.5         | 1,275.0    |
| Авлага                                       | 34.6           | 47.5            | 12.9         | 37.3       |
| Бараа материал                               | 48.4           | 78.4            | 30.0         | 62.0       |
| Үндсэн хөрөнгө                               | 1,254.7        | 1,306.5         | 51.8         | 4.1        |
| Хөрөнгө оруулалт                             | 50.2           | 50.2            | -            | -          |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>1,389.9</b> | <b>1,510.1</b>  | <b>120.2</b> | <b>8.6</b> |
| Дансны өглөг                                 | 6.3            | 13.2            | 6.9          | 109.5      |
| Хойшлогдсон татварын өр                      | 300.0          | 370.6           | 70.6         | 23.5       |
| Засгийн газрын хувь оролцоо                  | 1,572.4        | 1,572.4         | -            | -          |
| Дахин үнэлгээний нэмэгдэл                    | 86.3           | 86.3            | -            | -          |
| Хуримтлагдсан ашиг                           | (575.1)        | (532.4)         | 42.7         | (7.4)      |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1,389.9</b> | <b>1,510.1</b>  | <b>120.2</b> | <b>8.6</b> |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны үр дүнгээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27.5 сая төгрөг буюу 13.7 дахин нэмэгдсэн байна.
- Дансны авлагын үлдэгдэл 12.9 сая төгрөг буюу 37.3 хувиар нэмэгдсэн нь тайлант онд ус дулааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой айл өрхийн авлага өсөх хандлагатай
- Бараа материал дансны үлдэгдэл 30.0 сая төгрөг 62.0 хувиар нэмэгдсэн нь бараа бүтээгдэхүүний үнэ ханш өссөнтэй холбоотой ба сангийн болон авто сэлбэгийн нөөц бүрдүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 51.8 сая төгрөг буюу 4.1 хувиар нэмэгдсэн нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан болон данснаас дансанд шилжиж ирсэн,

үнэ төлбөргүй хүлээн авсан, актлаад шинээр үнэлсэн зэрэгтэй холбоотой байна.

- Өр төлбөр 6.9 сая төгрөг буюу 109.5 хувиар нэмэгдсэн нь ХХОАТ, ажилчин албан хаагчдад өгөх өглөг зэрэг өглөгүүд нэмэгдсэн байна.
- Хойшлогдсон татварын өглөг 70.6 сая төгрөг буюу 23.5 хувиар нэмэгдсэн нь өмнөх оны үлдэгдлээс 35.4 сая төгрөгөөр бууруулж, тайлант онд 106.0 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.
- Хуримтлагдсан алдагдал 42.7 сая төгрөг буюу 7.4 хувиар буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ нь 2022 оны орлого, зарлагын төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 501.7 сая, нийт зардлыг 483.7 сая төгрөгөөр төлөвлөж, 18.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тооцсон байна.

Гүйцэтгэлээр 583.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 523.2 сая төгрөгийн зардал гарган, 60.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 2. Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

| №  | Зардлын нэр                    | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт, хэтрэлт |       |
|----|--------------------------------|------------|-----------|------------------|-------|
|    |                                |            |           | Дүн              | Хувь  |
| 1  | Цалингийн зардал               | 217.9      | 210.0     | (7.9)            | -3.6  |
| 2  | ЭМД ба НДШ зардал              | 31.6       | 30.0      | (1.6)            | -5.1  |
| 3  | Гэрээт ажилчдын төлбөр         | 7.0        | 10.1      | 3.1              | 44.3  |
| 4  | Материалын зардал              | 25.9       | 35.1      | 9.2              | 35.5  |
| 5  | Нүүрсний зарцуулалт            | 49.5       | 41.4      | (8.1)            | -16.4 |
| 6  | Шатахууны зарцуулалт           | 22.9       | 31.3      | 8.4              | 36.7  |
| 7  | Тээврийн зардал                | 2.6        | 1.8       | (0.8)            | -30.8 |
| 8  | Бичиг хэргийн зардал           | 0.8        | 1.2       | 0.4              | 50.0  |
| 9  | Шуудан холбооны зардал         | 4.7        | 3.1       | (1.6)            | -34.0 |
| 10 | Цахилгааны зардал              | 31.3       | 24.2      | (7.1)            | -22.7 |
| 11 | Сургалтын зардал               | 1.3        | 2.5       | 1.2              | 92.3  |
| 12 | Томилолтын зардал              | 1.2        | 0.8       | (0.4)            | -33.3 |
| 13 | Хог хаягдлын зардал            | 0.6        | 1.2       | 0.6              | 100.0 |
| 14 | Засварын зардал                | 4.5        | 2.0       | (2.5)            | -55.6 |
| 15 | Хөдөлмөр хамгааллын зардал     | 1.4        | 5.4       | 4.0              | 285.7 |
| 16 | Аудитын төлбөр                 | 2.0        | 2.0       | -                | 0.0   |
| 17 | Даатгалын зардал               | 0.6        | 0.6       | -                | 0.0   |
| 18 | Зохицуулах үйлчилгээний төлбөр | 1.6        | 1.6       | -                | 0.0   |
| 19 | Шинжилгээний төлбөр            | 0.3        | 0.4       | 0.1              | 33.3  |
| 20 | Газрын төлбөр                  | 0.2        | 0.3       | 0.1              | 50.0  |
| 21 | ҮХХАТатвар                     | 2.6        | 1.2       | (1.4)            | -53.8 |
| 22 | Ус рашааны татвар              | 0.5        | 0.4       | (0.1)            | -20.0 |

|                          |                                    |              |              |             |             |
|--------------------------|------------------------------------|--------------|--------------|-------------|-------------|
| 23                       | АМӨЯХАТатвар                       | 0.3          | 0.3          | -           | 0.0         |
| 24                       | Агаарын бохирдлын төлбөр           | 0.0          | 0.0          | -           | 0.0         |
| 25                       | Авто зам ашиглалтын төлбөр         | 0.0          | 0.0          | 0.0         | 33.3        |
| 26                       | БОАТатварын зардал                 | 3.0          | 6.8          | 3.8         | 126.7       |
| 27                       | МНААҮХолбооны гишүүнчлэлийн татвар | 1.6          | 1.5          | (0.1)       | -6.3        |
| 28                       | Ажилчдын нийгэм хамгаалал          | 1.0          | 1.4          | 0.4         | 40.0        |
| 29                       | Үйл ажиллагааны бусад зардал       | 6.0          | 8.4          | 2.4         | 40.0        |
| 30                       | Буцалтгүй тэтгэмж                  | 1.7          | 1.1          | (0.6)       | -35.3       |
| 31                       | Шагнал урамшууллын зардал          | 2.5          | 4.2          | 1.7         | 68.0        |
| 32                       | Байгууллага хөгжүүлэлтийн зардал   | 2.5          | 23.8         | 21.3        | 852.0       |
| 33                       | Үндсэн хөрөнгийн элэгдэл           | 54.0         | 53.8         | (0.2)       | -0.4        |
| 34                       | Хөрөнгө оруулалтын зардал          | 0.0          | 15.2         | 15.2        | 100.0       |
| <b>Нийт зарлагын дүн</b> |                                    | <b>483.7</b> | <b>523.2</b> | <b>39.5</b> | <b>8.2</b>  |
| 1                        | Дулаан                             | 486.9        | 471.3        | (15.6)      | -3.2        |
| 2                        | Цэвэр бохир ус                     | 14.8         | 39.6         | 24.8        | 167.6       |
| 3                        | Бусад орлого                       |              | 72.9         | 72.9        | 100.0       |
| <b>Нийт орлогын дүн</b>  |                                    | <b>501.7</b> | <b>583.8</b> | <b>82.1</b> | <b>16.4</b> |
| <b>Ашиг/алдагдал</b>     |                                    | <b>18.0</b>  | <b>60.6</b>  | <b>42.6</b> | <b>8.2</b>  |

Дээрх хүснэгтээс харахад:

Нийт орлогын гүйцэтгэл 583.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 82.1 сая төгрөг буюу 16.4 хувиар давж биелэгдсэн нь тайлант хугацаанд ус, дулааны үнэ нэмэгдсэн ба сумын ОНХС-аас гэрээгээр ажил гүйцэтгэсэнээр бусад орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 523.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 39.5 сая төгрөг буюу 8.2 хувиар хэтэрсэн нь нүүрс, шатахуун, сэлбэг зэрэг гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн ба төлөвлөгдөөгүй гэнэтийн зардал /салбарын харьяа дээд байгууллагаас ундны усны чанар байдлын судалгааны оролцоо/ гарсантай холбоотой байна.

Тайлант онд цэвэр ашиг 60.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 42.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Саруул баян уул-Аудит” ХХК-ийн захирал Б.Шатар, аудитор Д.Оюунбат нар гүйцэтгэж, хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын

менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Саруул баян уул-Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнгээр суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтээс 1 хувийг сонгож, төлөвлөлтийн материаллаг байдлыг 13.9 сая төгрөгөөр тооцсон ба санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 9.7 сая төгрөгөөр тогтоож, материаллаг байдлыг дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

## **4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Тус байгууллага нь тайлант жилд 583.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 523.2 сая төгрөгийн зардал гарган, 60.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлого ашгаа нэмэгдүүлэхийн тулд сумын ОНХС-аас гэрээгээр ажил гүйцэтгэж, үндсэн үйл ажиллагааны бус орлого нэмэгдсэн байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт**

Татварын ерөнхий хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүйгээс 2.3 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8, 28 дугаар зүйлийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5, 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авалт хийсэн тухай бүр цахим төлбөрийг И баримт системд бүртгүүлж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалт он тулгаж хийгдсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                | Биелэлт |                |            |
|-----------------|------------------------|----------------|---------|----------------|------------|
|                 | Тоо                    | Дүн            | Тоо     | Дүн            | Хувь       |
| Акт             |                        |                |         |                |            |
| Албан шаардлага | 3                      | 251.8          | 3       | 251.8          | 100        |
| Зөвлөмж         | 5                      | 867.1          | 5       | 867.1          | 100        |
| <b>Нийт дүн</b> |                        | <b>1,118.9</b> |         | <b>1,118.9</b> | <b>100</b> |

Өмнөх аудитаар 3 албан шаардлага, 5 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар залруулах алдаа илрээгүй.

Аудитаар нийт 0.1 сая төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрсэн бөгөөд зөрчлийг арилгуулах зөвлөмж өгсөн байна.

### 5.1. Төлбөрийн акт байхгүй

### 5.2. Албан шаардлага байхгүй

### 5.3. Зөвлөмж

#### 1. Цалин хөлс, НДШ-тэй холбоотой

##### 1.1. Илрүүлэлт

НДШ-ийн тайланд 102.0 мянган төгрөгийн цалин дутуу тайлагнасан.

НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3 дахь заалтыг тус тус зөрчсөн

##### Өгсөн зөвлөмж:

НДШ-ийн тооцоог үнэн зөв хийж, сар бүр тайлагнаж байх

#### 2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

##### 2.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2017 онд батлагдсан НБББББ-т мөрдөхөөр заасан НББОУС-18, НББОУС-11, НББОУС-17 стандартууд хүчингүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** НБББББ-ийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, заавар журамд нийцүүлэн дахин боловсруулах

Дээрх 2 зөвлөмжийн биелэлтийг “Саруул баян уул -Аудит” ХХК-д 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                        | Нийт зөрчил |            | Үүнээс        |     |                 |     |          |            |                                      |              |   |     |
|---|-------------|------------|---------------|-----|-----------------|-----|----------|------------|--------------------------------------|--------------|---|-----|
|   |             |            | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |            | Хариуцлага тооцуулах албан шаардлага |              | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн        | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн        | Тоо                                  | Албан тушаал | Тоо   | Дүн |
| НДШ-ийн тайланд цалин дутуу тайлагнасан.  | 1           | 0.1        |               |     |                 |     | 1        | 0.1        |                                      |              |   |     |
| НБББББ-ийн зарим стандарт хүчингүй болсон | 1           | 0          |               |     |                 |     | 1        | 0          |                                      |              |   |     |
| <b>дүн</b>                                | <b>2</b>    | <b>0.1</b> |               |     |                 |     | <b>2</b> | <b>0.1</b> |                                      |              |   |     |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |            | Үүнээс        |     |                 |     |          |            |
|---|-------------|------------|---------------|-----|-----------------|-----|----------|------------|
|   |             |            | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |            |
|   | Тоо         | Дүн        | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн        |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил  |             |            |               |     |                 |     |          |            |
| Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй | 1           | 2.3        |               |     |                 |     | 1        | 2.3        |
| <b>дүн</b>  | <b>1</b>    | <b>2.3</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>2.3</b> |
| <b>Нийт дүн</b>   | <b>3</b>    | <b>2.4</b> |               |     |                 |     | <b>3</b> | <b>2.4</b> |